

ЗӨВЛӨМЖ

Бага оврын усан тээврийн хэрэгслийг хадгалах

Бага оврын усан тээврийн хэрэгсэл /завь/-ийг аливаа элэгдэл, гэмтлээс хамгаалахын тул өвлийн улиралд зөв хадгалах шаардлагатай. Завины насжилтыг уртасгах, удаан хугацаанд ашиглах нь техник ашиглалтын болон арчлалт, хамгаалалтын зөв горимоос ихээхэн шатгаална.

Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн улирал дуусмагц тухайн тээврийн хэрэгслийг зайлшгүй өвлийн хамгаалалт, аюулгүй зогсолтыг хийх ёстой. Хөдөлгүүр, сэнс болон бусад тоног төхөөрөмж, эд ангийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хадгална.

Завийг өвөлд бэлдэхэд хамгийн түрүүнд түүнийг уснаас гаргана. Завийг усан дээр өвөлжүүлэхийг хориглоно. Завийг уснаас гаргахын өмнө аврах хэрэгсэл, засварын хэрэгсэл, хөдөлгүүр, сэнс, суудал, түлшний сав зэргийг салгаж авна. Аккумулятор, харилцаа, холбооны хэрэгсэл, бусад цахилгаан тоног, төхөөрөмжийг зайлшгүй салгах авах шаардлагатай. Завийг зориулалтын чиргүүл дээр өвлийн зогсоол руу нь тээвэрлэнэ.

Завийг битүү, хуурай агааржуулалт сайтай байранд хадгалбал тохиромжтой. Хэрвээ хадгалах зориулалтын байр байхгүй бол

бороо, цас нэвтрэхээр газраас тодорхой өндөрт хөндий байрлуулж, цас болон борооны ус, салхи нэвтрэхээргүй даавуу, хучлагаар хучна. Мөн хучлаган дотор хэт чийг цохиулахаас сэргийлж, агаар нэвтрүүлж байх шаардлагатай. Завинд засвар хийхэд тохиромжтой байхаар зориулан газраас 1 метрийн өндөрт тулгуур хийж хадгалбал илүү тохиромжтой. Салгаж авсан тоног төхөөрөмжүүдийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу шалгана.

Завийг хадгалахдаа галын аюулгүй байдлын дүрмийг сахиж хадгалах бөгөөд тээврийн хэрэгсэл болгонд хадгалалтын зөв горим сахиулах шаардлагатай.

Модон завь

Модон завины хувьд нарийн арчилгаа, үйлчилгээ шаарддаг бөгөөд өвлийн нөхцөлд хадгалахдаа модон дэвсгэр дээр байрлуулж хадгалдаг. Хэрэв түүнийг газар байрлуулж хадгалах тохиолдолд их биеийн мод ялзарч муудах аюултай учир уснаас гаргасны дараа усанд байрлах ёроолын хэсгийг нэн түрүүнд сайтар угаана. Ёроолд наалдсан нарийн элс шороо, замаг, хясааг сойз ашиглан сайтар угаана. Их биеийн тосыг арилгахын тулд бензин, керосин ашиглаж болно. Завины ёроол хэсгийг савандаж угаан хатааж, арчиж өнгө дагуу будгаар будна. Муудсан хэсгүүдийг солих, нөхөх хэрэгтэй. Жижиг нүх, ором нь өтний авгалдай үүрлэсэн байх магадлалтай юм. Энэ тохиолдолд 10-15%-ийн байвангийн уусмалыг нүхэнд нь шингээж арчина. Бүх булан хэсгүүдийг хатсаны дараа

лакаар лақдана. Завь бүрэн хатсаны дараа будгийн ажлыг эхлүүлж болно. Модон хэсгүүд дээр хөгц үүссэн бол эдгээр газрууд нь цайруулагч эсвэл бусад сул цайруулагч уусмалаар угаана. Мөн дотор хэсгийг сайтар угааж, хатаана.

Хийлдэг завь

Хийлдэг завийг уснаас гарган элс, тосны толбо зэргийг савантай усаар сайтар угаах шаардлагатай. Угаахдаа зөвхөн хүйтэн усаар угаана. Угаахын өмнө бүх агаарын хаалтуудыг хаахаа битгий мартаарай. Энэ тохиолдолд баллон дотор ус орох аюултай. Угааж цэвэрлэсэн завийг хатаахдаа доод хэсгийн нугалааснуудын хатаалтыг сайтар ажиглах шаардлагатай. Олон сарын турш хадгалахад бага зэргийн чийг хүртэл резинэн гадаргууг гэмтээх аюултай байдаг. Мөн үүний зэрэгцээ гадна талын урагдалт, зүсэлт гэмтсэн эсэхийг шалгана. Хэрвээ гэмтсэн бол тухайн хэсгийг маркераар тэмдэглэж нааж засварлах шаардлагатай.

Хийлдэг завийг хуурай дулаан нөхцөлд газраас хөндий байршилд хадгална. Гаражид таазнаас дүүжилж хадгалах нь тохиромжтой. Энэ арга нь мэрэгч амьтад завийг гэмтээж, цоолохоос хамгаалж буй хэрэг юм. Хэрвээ хадгалах зай бага байгаа тохиолдолд бүх хийг нь гаргаж гадаргуун дээр нь тальк цацаж хадгалж болно. Энэхүү тохиолдолд өвлийн турш 2-3 удаа завийг задалж дахиж эвхэж байхыг зөвлөж байна.

Төмөр завь

Төмөр завийг уснаас гаргасны дараа төмөр сойзоор сайтар угаана. Завины ёроолыг нь сайтар угааж, хатаах шаардлагатай. Хүйтний улиралд хадгалахад чийгийг хгадагшлуулахын тулд хаалга дээврийг нь онгорхой орхиж, доторх эд ангийг даавуугаар хучина. Металл эд ангиудыг зэврэлтээс хамгаалахын тул зайлшгүй салган авах шаардлагатай. Дараа нь шаардлагатай хэсгүүдэд зэвнээс хамгаалах тосолгоог хийж болно.

“Fiberglass” завь

“Fiberglass” завийг уснаас гаргасны дараа сайтар мөн угаана. Завины гадаргууг угаахдаа хатуу сойз, материал ашиглаж болохгүй. Ихэвчлэн даралттай усаар зориулалтын төхөөрөмжөөр үүнийг гүйцэтгэнэ. Гэмтсэн гадаргууг будах юм уу бусад засварыг хийнэ. Завинд гэмтэл үүсгэхээс сэргийлж түүн дотор тогтсон усыг үлдээж болохгүй. Завины гадаргууд нарны шууд тусгал тусах нь халалт үүсгэх зэрэг муу талтай учраас хамгаалалтын хучлагаар бүтээж, хадгалах хэрэгтэй.

Удаан хугацаанд ашигласан “Fiberglass” завины их биеийн гадаргуу дээр товруунууд үүссэн байдаг ба хэрэв бага зэргийн хэмжээний товруунууд үүссэн бол түүнийг ацетоноор арчиж 7 хоногийн турш хатаана. Дараа нь гэмтсэн хэсгийг эпокси сууртай будгаар будаж, нөхөөс давирхайг нүхнүүдэд

дүүргэж, дараа нь будгаар давхарлан будах хэрэгтэй.

Хэрвээ томоохон хэмжээтэй товруунууд үүссэн бол завийг зайлшгүй засварт оруулах шаардлагатай гэсэн үг. Энэх үед завийг засварт оруулаагүй бол их бие ноцтой гэмтэж, ашиглах боломжгүй болно. Дотоод эд ангийг агаар сайн орж байхаар өвөлд бэлтгэх хэрэгтэй. Орох хаалга, хаалт, люкыг онгойлгож орхих хэрэгтэй. Доторх чийгийг гаргахын тулд тусгай бодис шингээсэн даавууг ашиглах нь зүйтэй.

--oOo--

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ДАЛАЙН ЗАХИРГАА

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр, 603 тоот

Утас: 70134802, 51-261489

Факс: (976-11) 310642

И-мэйл: info@monmarad.gov.mn

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГАА



БАГА ОВРЫН УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН
ХЭРЭГСЛИЙН ӨМЧЛӨГЧ БОЛОН ЖОЛООЧ
НАРТ ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

**/Бага оврын усан замын тээврийн
хэрэгслийг хадгалах/**

Улаанбаатар хот
2020 он